Сагсай сумын Засаг дарга нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тайлант онд тус албанаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхтэй холбоотой Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,060.1 сая төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	293.7	365.1	71.4
Авлага	260.9	215.7	(45.3)
Урьдчилж гарсан зардал			-
Бараа материал	49.7	62.4	12.6
Нөөцийн бараа	27.3	40.0	12.7
Үндсэн хөрөнгө	4,120.0	4,377.0	257.0
Нийт хөрөнгө	4,751.6	5,060.1	308.5
Өр төлбөр	5.9	4.7	(1.2)

/сая төгрөгөөр/

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,745.7	5,055.5	309.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,751.6	5,060.1	308.5

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Судалгаанаас мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 293.7 сая төгрөг болж, өмнөх оноос 84.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	293.7	365.1	71.4
Төгрөг	293.7	365.1	71.4
Төрийн сангийн харилцах	286.9	348.1	61.2
Арилжааны банк дахь харилцах	6.8	17.0	10.2
Дүн	293.7	365.1	71.4

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө данс оны эхний үлдэгдэлтэй 71.4 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын данс, ОНХС, ХХС, эргэлтийн эмийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Орон нутгийн ерөнхий орлогын данс 280.7 сая төгрөгийн, ОНХС-гийн данс 5.2 сая төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн данс 62.2 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн сангийн данс 17.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 215.7 сая төгрөг болж, өмнөх оноос 45.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	0.1	0.1	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	4.5	0.4	(4.0)
Байгууллагаас авах авлага	-	-	-
Хувь хүмүүсээс авах авлага	0.1	0.0	(0.0)
Зээлийн авлага	256.3	215.1	(41.2)
Хувь хүмүүст олгосон зээл	256.3	215.1	(41.2)
Дүн	260.9	215.7	(45.3)

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 45.3 сая төгрөгөөр буурсан нь сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 41.2 сая, зээлийн хүүгийн авлага 4.0 сая, хувь хүмүүсээс авах авлага 0.1 сая төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна. Тайлант онд ХХС-гаас зээл олгоогүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлага данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 62.4 сая төгрөг болж, өмнөх оноос 12.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	12.7	15.4	2.7
Эм боох материал	12.7	15.4	2.7
Хангамжийн материал	37.0	46.9	10.0
Бичиг хэргийн материал	1.4	0.4	(1.1)
Аж ахуйн материал	35.5	39.7	4.2
Түлш, шатах тослох материал	-	6.8	6.8
Бусад хангамжийн материал	-	-	-
Мал амьтад	-	-	-
Дүн	49.7	62.4	12.6

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Бараа материалын данс 12.6 сая төгрөгөөр өссөн нь сумын ЗДТГ-ын аж ахуй, түлш шатах тослох материалын үлдэгдлээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Нөөцийн бараа оны эхэнд үлдэгдэлгүй, оны эцэст сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 12.7 сая төгрөгийн тэжээлийн нөөцийн үлдэгдэлтэй гарсан байна. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 40.0 сая төгрөгийн тэжээлийн нөөц бэлтгэсэн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн буюу Нөөцийн бараа үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Нөөцийн бараа	27.3	40.0	12.7
Тэжээлийн нөөц	27.3	40.0	12.7
Дүн	27.3	40.0	12.7

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,377.0 сая төгрөг болж, өмнөх оноос 257.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,458.9	3,714.6	255.7
Барилга, байгууламж, орон сууц	583.8	864.5	280.7
Авто-тээврийн хэрэгсэл	84.3	67.0	(17.3)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	72.5	75.5	3.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	39.6	34.1	(5.5)
Зам, гүүрийн байгууламж	1,867.5	1,821.5	(46.0)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	779.4	852.1	72.7
Дуусаагүй барилга, байгууламж	31.8	-	(31.8)
Ном	-	-	-
Биет бус хөрөнгө	661.0	662.3	1.3
Программ хангамж	-	1.3	1.3
Бусад биет бус хөрөнгө	661.0	661.0	-
Дүн	4,120.0	4,377.0	257.0

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Үндсэн хөрөнгийн данс 257.0 сая төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө болон аймаг, сумын ОНХС-гийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.
- Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлангаар төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 115.6 сая төгрөгийн хөрөнгийг зардлаар тайлагнаж ирүүлснийг аудитаар залруулсан.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн данс оны эцэст 4.7 сая төгрөг болж, 1.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	5.9	4.7	(1.2)
Ажилчидтай холбогдсон өглөг	-	2.0	2.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	5.9	2.6	(3.2)
Бусад өглөг	-	-	-
Байгууллагад төлөх өглөг	-	-	-
Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-
Дүн	5.9	4.7	(1.2)

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өр төлбөр данс оны эхний 3.3 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, шинээр 2.0 сая төгрөгийн ЗДТГ-ын ажиллагсадтай холбоотой өглөгтэй гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- **Өглөг данстай холбоотой зөрчил гараагүй.**

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,120.1 сая төгрөг болж, тайлант оны үр дүнгийн хэмжээгээр 309.7 сая төгрөгөөр өссөн байна..

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,120.1	1,120.1	-
Хуримтлагдсан үр дүн	2,226.7	2,536.4	309.7
Өмнөх үеийн үр дүн	8,283.1	2,226.7	(6,056.4)
Тайлант үеийн үр дүн	(6,056.4)	309.7	6,366.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,398.9	1,398.9	-
Дүн	4,745.7	5,055.5	309.7

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сагсай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,679.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,418.0 сая төгрөгийг урсгал зардалд, 261.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 588.2 сая төгрөгийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 782.7 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогын санхүүжилтээр, 247.8 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 61.2 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сагсай сум нь 2023 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,600.4 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс улсын төсвөөс 588.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, сумын орон нутгийн төсвөөс 714.2 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 247.8 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 50.3 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой 41.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, оны эцэст орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 27.5 сая төгрөгийг төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагааны орлого /хоршоо хөгжүүлэх сан/ 10.9 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,559.7 сая төгрөг буюу 92.8 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 50.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 132 дугаар тогтоолоор Сагсай сумын 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 520.0 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2023 оны 192 дугаар тодотголоор 527.9 сая төгрөгөөр буюу 7.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 72 дугаар хуралдааны тогтоолоор 2023 орлогын төлөвлөгөөг 527.9 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.

Гүйцэтгэлээр сумын орон нутгийн төсвийн орлогод нийтдээ 768.7 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 201.4 сая төгрөгөөр буюу 38.1 хувиар давуулан биелүүлсэн байна. Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 39.4 сая төгрөг олгосон байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Төлөвлөгөө</u>	<u>Гүйцэтгэл</u>	<u>Өсөлт/+, бууралт /-/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
I.Татварын орлого	520.6	711.5	190.8	136.7
II.Татварын бус орлого	7.3	17.8	10.5	245.4
Нийт дүн	527.9	729.3	201.4	138.1

Орон нутгийн орлого төлөвлөгөө давж биелэгдэхэд цалин хөлсний орлогоос 325.7 сая, хөрөнгө борлуулсны орлогоос 0.2 сая төгрөгөөр давж биелэгдэн, орлогын төлөвлөгөө өгөгдөөгүй малд ногдуулах албан татвараас 22.7 сая төгрөгийн, дуудлага худалдааны орлогоос 10.4 сая, шүүхийн шийдвэрээр иргэний торгох ял авсны орлогоос 0.9 төгрөгийн орлого оруулсан нь орон нутгийн орлого давж биелэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос үйл ажиллагааны орлогын албан татвар 27.4 сая, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 9.7 сая, бууны албан татвар 1.5 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 18.6 сая, улсын тэмдэгтийн хураамж 0.3 сая, хог хаягдлын хураамж 7.1 сая, ойн нөөцийн төлбөр 1.8 сая, газрын төлбөр 7.4 сая, хүү, торгуулийн орлого 0.7 сая төгрөгөөр тус тус тасарсан бол үл хөдлөх хөрөнгийн татвар, ан амьтны нөөц ашигласны төлбөр 100 тасарсан байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 257.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 768.7 сая төгрөгийн татварын орлого оруулж, орон нутгийн төсвийн төвлөрүүлэлтийн орлогоос 30.8 сая төгрөгийн санхүүжилтийн төвлөрч, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 280.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

/сая төгрөг/

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	119.3	113.7	-5.5
2	Сумын ЗДТГ	879.1	818.2	-61.0
3	Ерөнхий боловсролын 1-р сургууль	232.1	232.0	-0.2
4	Ерөнхий боловсролын 2-р сургууль	18.3	17.8	-0.5
5	Хүүхдийн 1-р цэцэрлэг	33.1	33.1	-
6	Хүүхдийн 2-р цэцэрлэг	17.9	17.9	-
7	Хүүхдийн 3-р цэцэрлэг	12.1	12.1	-
8	Соёлын төв	27.9	27.7	-0.1
9	Эрүүл мэндийн төв	31.3	30.0	-1.3
10	ОНХСан	247.8	247.8	-
11	СХС	61.2	50.3	-10.9
Нийт дүн		1,679.9	1,600.4	-79.5

Үүнээс сумын ИТХ-ын 5.5 сая, ЗДТГ-ын 41.1 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь төсвийн зарлагыг үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 15.5 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 25.7 сая төгрөгийн нийтдээ 41.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, хангамж, бараа материалын зардалд 1.1 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 36.7 сая төгрөгийг хамруулан зарцуулж, оны эцэст 3.4 сая төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланг 2024 оны 3 дүгээр сарын 06-ны өдрийн 01/76 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,315.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 19.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд үйл ажиллагаатай хамааралтай 2 шалгуурт алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 19.4 сая төгрөгийн 3 орлогын, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 218.9 сая төгрөгийн зарлагын 18 мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 79.1% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчид завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгдөөгүй байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар сумын Засаг дарга нарт “Малын татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, орлогыг сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажиллах” талаар зөвлөмж өгөгдсөн бөгөөд Сагсай сум нь малын татварын орлогыг сумын ИТХ-аар батлуулж ажиллаагүй ажиллаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 218.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 217.7 сая төгрөгийн залруулга хийгдэж, 1.1 сая төгрөгийн акт тогтоосон байна.

Хүснэгт №4: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сагсай сумын Засаг даргын тамгын газар	2	218.8	1	217.7	1	1.1				
2	Сагсай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Сагсай сумын ОНХСан	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Сагсай сумын Хоршоо хөгжүүлэх сан	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн		2	218.8	1	217.7	1	1.1	-	-	-	-

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 20.2 сая төгрөгийн алдаа¹ илэрч 20.2 сая төгрөгийн алдаа аудитын явцад залрууллаа. Залруулсан алдаа:

- ТТЗ-ийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг сумын орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг 20.2 сая төгрөгөөр илүү тайлагнаж ирүүлснийг залруулав.

Аудитаар нийт 238.3 сая төгрөгийн зөрчил² илэрч албан шаардлага өгөгдсөн.

1. Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой тайлантай холбоотой 238.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч албан шаардлага, өгөгдлөө.

1.Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 19.4 сая төгрөгийн 3 орлогын, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 218.9 сая төгрөгийн зарлагын 18 мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 79.1% байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөө.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг үзүүлэлтийг үнэн зөв тайлагнаагүй	1	20,177.3					1	20,177.3				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн	1	20,177.3					1	20,177.3				
-----	---	----------	--	--	--	--	---	----------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад орлогын 3, зарлагын 18 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй	1	238,327.2			1	238,327.2		
Дүн	1	238,327.2			1	238,327.2		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								